



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 464,205,678.06 (дөрвөн зуун жаран дөрвөн сая хоёр зуун таван мянга зургаан зуун далан найман төгрөг зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.”Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хассан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ируулэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.



ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

3.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000651

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06. өдрийн
100 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН

ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ

АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ		Үлдэгдэл өртөг
			Нэг бурийн үнэ	НИЙТ ҮНЭ, хуримтлагдс ан элэгдэл	
/Төгрөг/					
1	Газель, 3927 OPX арал 270500-70346989	2008	156,896,879.50	156,896,879.50	0.00
2	Чирэгч татара-815 6015 OPX арал TNT815VN8KK096678	2008	221,826,423.56	221,826,423.56	0.00
3	Шатахуун тээвэрлэгч 8 m33052 OPO арал FR2PB10058	2011	85,482,375.00	85,482,375.00	0.00
	НИЙТ ДҮН			464,205,678.06	
			(дөрвөн зуун жаран дөрвөн сая хоёр зуун таван мянга зургаан зуун далан найман төгрөг зургаан мөнгө)		